## ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....3
1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал.....7
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....10
2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга .....10
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....17
3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....17
БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....19
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ ХАМГААЛАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....21
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....22
БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....24
БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....25
БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....26
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....27
БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....29
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....30

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд .....3
Хүснэгт 2. Ажиллах хүчин .....8
Хүснэгт 3. Техник, тоног төхөөрөмжийн жагсаалт.....9
Хүснэгт 4. Цогтцэций сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт .....14
Хүснэгт 5. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл .....17
Хүснэгт 6. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэгтгэл 5 жилээр .....19
Хүснэгт 7. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал..19
Хүснэгт 8. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ.....21
Хүснэгт 9. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....22
Хүснэгт 10. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....24
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....25
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....26
Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....27
Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....29
Хүснэгт 15. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....30

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Засаг захиргааны зураг .....4
Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг .....5
Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг.....6
Зураг 4. Төслийн талбайн фото зураг .....7
Зураг 5. Үйлдвэрийн технологийн процесс .....7
Зураг 6. Үйлдвэрийн технологийн шат дамжлага №1 .....8
Зураг 7. Үйлдвэрийн технологийн шат дамжлага №2 .....8
Зураг 8. Төслийн талбайн районы д.т.д өндөршлийн зураг (метр).....11
Зураг 9. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус) .....12
Зураг 10. Агаарын жилийн дундаж температур, жилийн нийлбэр хур тунадас.....13
Зураг 11. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн хандлага.....14
Зураг 12. Төслийн талбайн ногоон байгууламжийн төлөвлөлтийн зураг.....23
Зураг 13. ОХШХ-ийн зураг .....28

## БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

***Төслийн нэр:*** “Бетон зуурмагийн үйлдвэр”-ийн төсөл.

***Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:***

| | |
|---|---|
| *Төслийн нэр:* | ▪ “Бетон зуурмагийн үйлдвэр” |
| *Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр:* | ▪ “Өгөөмөр мандал хайрхан” ХХК<br>- Улсын бүртгэлийн дугаар: 1111016343<br>- Регистрийн дугаар: 3643042 |
| *Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас* | ▪ Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг, Далан, 23, 2-17 тоот<br>▪ Утас: 976-95116969 |
| *Төслийн товч танилцуулга, хүчин чадал* | ▪ Тус бетон зуурмагийн үйлдвэр нь цагт 40 м$^3$ зуурах хүчин чадалтай орчин үеийн бүрэн удирдлагын системтэй бүрэн автомат үйлдвэр бөгөөд технологийн горим ажиллагааны хувьд өндөр нарийвчлалтай тасралтгүй ажиллагаатай иж бүрэн үйлдвэр юм. |

***Төслийн байршил:***


“Өгөөмөр мандал хайрхан” ХХК-ийн төслийн талбай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 1-р багийн нутагт байрлана.

- Талбайн хэмжээ: 1.25 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: К-48-8


***Газарзүйн солбицол:***

*Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд*


| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 105 | 35 | 41.4 | 43 | 43 | 8.5 |
| 2 | 105 | 35 | 46.6 | 43 | 43 | 9.9 |
| 3 | 105 | 35 | 48.2 | 43 | 43 | 6.8 |
| 4 | 105 | 35 | 42.9 | 43 | 43 | 5.4 |




*Зураг 1. Засаг захиргааны зураг*




*Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг*




*Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг*

### 1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал


Тус компани нь 2021 оноос эхлэн өнөөг хүртэл Өмнөговь аймгийн Цогтцэций суманд бетон зуурмаг үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж улс, сум орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтын ажилд хувь нэмэр оруулан ажиллаж байна.




*Зураг 4. Төслийн талбайн фото зураг*

***Төслийн хүчин чадал:***


Тус бетон зуурмагийн үйлдвэр нь цагт 40 $м^3$ зуурах хүчин чадалтай орчин үеийн бүрэн удирдлагын системтэй бүрэн автомат үйлдвэр бөгөөд технологийн горим ажиллагааны хувьд өндөр нарийвчлалтай тасралтгүй ажиллагаатай иж бүрэн үйлдвэр юм.




*Зураг 5. Үйлдвэрийн технологийн процесс*




*Зураг 6. Үйлдвэрийн технологийн шат дамжлага №1*



*Зураг 7. Үйлдвэрийн технологийн шат дамжлага №2*

Тус үйлдвэр нь нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй, ажилчдын дундаж цалин 2,5 сая төгрөг байна. Сайн ажилласан ажилчдад жилийн эцсээр урамшуулал олгодог. Ажилчдаа тогтвор суурьшилтай, идэвх санаачлагчтай ажиллуулах чиглэлд цалин хөлснөөс гадна, ажилчдын нийгмийн байр суурь ахуй амьдрал орон байрны асуудал зэргийг байгууллагын нөөц бололцоогоор шийдвэрлэн дэмжиж ажиллаж байна.

*Хүснэгт 2. Ажиллах хүчин*

| № | Ажилчид | Тоо, ширхэг |
|---|---|---|
| 1 | Захирал | 1 |
| 2 | Үйл ажиллагааны менежер | 1 |
| 3 | Технологи инженер | 1 |
| 4 | Талбайн инженер | 1 |
| 5 | ХАБЭА хариуцсан менежер | 1 |

| № | Ажилчид | Тоо, ширхэг |
|---|---|---|
| 6 | Нягтлан бодогч | 1 |
| 7 | Нярав | 1 |
| 8 | Жолооч(зуурмагийн машин) | 4 |
| 9 | Жолооч(дугуйт ачигч) | 1 |
| 10 | Оператор | 2 |
| 11 | Цахилгаанчин | 1 |
| 12 | Туслах ажилтан | 1 |
| 13 | Тогооч | 1 |
| 14 | Цэвэрлэгч | 1 |
| 15 | Харуул | 1 |

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаанд бүрэн автомат зориулалтын техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглана. Доорх техник тоног төхөөрөмжүүдээр үйл ажиллагаа явуулж байна.

*Хүснэгт 3. Техник, тоног төхөөрөмжийн жагсаалт*

| № | Тоног төхөөрөмж | Тоо, хэмжээ |
|---|---|---|
| 1 | Бетон зуурмагийн үйлдвэр | 1 цогц |
| 2 | Бетон зуурмагийн машин | 4 ш |
| 3 | Цемент зөөх машин | 1 ш |
| 4 | Дугуйт ачигч | 1 ш |
| 5 | Авто жин | 1 ш |


# БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга


***Байгалийн бүс бүслүүр:*** Энэхүү судалгааны талбай нь Монгол орны байгалийн бүс бүслүүрийн, газарзүйн байршлын хувьд Монголын говь цөлийн хэсэгт байрладаг. Говь цөлийн бүс нь Монголын өмнөд, Хятадын хойд, баруун хойд хэсгээр үргэлжлэх ба Ази тивд орших хамгийн том цөлийн бүс юм. Хойд талаараа алтайн нуруу Монголын тал хээр нутаг, баруун өмнө талаараа Төвөдийн өндөрлөг, зүүн өмнө талаараа Хятадын тэгш өндөрлөгтэй залгана. Цогтцэций сумын нутагт Ундайн говь, Алтайн нурууны төгсгөл Их Шанхай, Цэций зэрэг нутгийн цэнхэр уулс, ургамал ногоо жигдэрсэн тэнүүн шаргал элс хосолсон үзэсгэлэнт Галбын говь зэрэг байгалийн үзэсгэлэн бүрдсэн 72,5 кв.км нутаг дэвсгэртэй. Тус сум нь үнэмлэхүй байрлалын хувьд Говь-Алтайн нурууны өмнөд хэсэгт оршдог. Сумын төв цэг нь 43°43'40,38" 105°34'25.51"солбицолд оршино. Сумын төв нь далайн төвшнөөс дээш 1486 м өндөрт, солбицолд байрладаг.

Тус сум нь харьцангуй байрлалын хувьд урд талаараа Өмнөговь аймгийн зүүн хэсэгт, баруун талаараа Ханхонгор, баруун хойд талаараа Цогт-Овоо, Хойд талаараа Дундговь аймгийн Өлзийт сум, зүүн талаараа Манлай , урд талаараа Баян-Овоо сумын нутагтай хил залган оршдог. Улаанбаатар хотоос 600 км, аймгийн төв Даланзадгад хотоос 161 км алслагдсан бөгөөд сумын нутгийн хилийн шугамын нийт урт нь 346.22 км ба Цогт-Овоо сумтай 56.5 км, Дундговь аймгийн Өлзийт сумтай 41.05 км, Манлай сумтай 97.93 км, Баян-Овоо сумтай 92.88 км, Ханхонгор сумтай 57.9 км тус тус хиллэнэ. Сумын нутаг дэвсгэрт Замтын ухаа, Эрдэнэ Овоо, Дааган дэл хад, Хал овоот толгой, Зогдор уул, Халивын баруун толгой, Хужирт хар толгой, Далангийн толгой, Цэций уул, Хадан шандын хар толгой, Их хонгор толгой, Гоёот уул зэрэг сүрлэг уулстай. Гучингийн сайр, Сайрын хоолой, Өнчингийн тал, Хужитийн тал, Цүнхийн тал, Хэсэг хавиргийн тал, Төхөмийн тал, Шар Төвгийн хоолой, Оорцогийн хоолой зэрэг тал, хөндий, хоолой зэрэг байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудтай.

***Физик газарзүйн мужлал:*** Тус судалгааны талбай нь цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газарзүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээрээ цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтдаг. Энэхүү бүс нутагт газар хөдлөлийн талаар урьд өмнө тусгайлсан судалгаа хийж байгаагүй бөгөөд Монгол орны чичирхийлэл, тектоникийн мужлалаар газар хөдлөлтийн 7 баллын бүсэд оршдог бөгөөд газар хөдлөлийн давтамж нь 1000 жилд хоёр удаа байх магадлалтай. Гадаргын зохион байгуулалтын талаар Дорнод говь, Алтайн өмнөх болон ар говиос ялгаатай, харин Монголын дорнод талтай төстэй гэж болно. Учир нь ухаа гүвээт тал ихэнх нутгийг эзэлнэ. Маш налуу хажуутай, ил гарсан хад чулуу бараг байхгүй ухаа, гүвээний хооронд их бага янз бүрийн хэмжээтэй хотос, тал газар байх бөгөөд түүнд хужир, марз цөөнгүй тогтоно.




*Зураг 8. Төслийн талбайн районы д.т.д өндөршилийн зураг (метр)*





*Зураг 9. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)*

**Өмнөговь аймгийн уур амьсгалын горим:** Нутаг дэвсгэрийн хэмжээ нь 165.4 мян км$^2$ бөгөөд хамгийн баруун цэгээс зүүн цэг хүртэл 700 км, хамгийн хойд цэгээс урд цэг хүртэл 400 км орчим зайтай. Өмнөд хэсгээрээ БНХАУ-тай, хойд хэсгээрээ Өвөрхангай, Дундговь аймгийн нутаг, зүүн хэсгээрээ Дорноговь аймгийн нутаг харин баруун хэсгээрээ Ханбогд хонгор аймгийн нутагтай хил залгаа оршдог.

Нутаг дэвсгэрийн хувьд хайрга чулуу элс ихтэй тачир сийрэг бэлчээрийн ургамалтай, уул нуруу, хонхор хөндий, тэгш тал, говь цөл алаглан оршдог. Эх газрын хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай, өргөргийн дагуу буюу баруун талын уулархаг нутгаасаа зүүн тийш говь уруугаа болох тусам дулаардаг хуурай агаартай хөрснөөс уурших чийгийн нөөц бага, агаар нэн хуурай учраас хур тунадасны хэмжээ бага, салхи ихтэй учир шороон шуургатай өдрийн тоо олон байдаг. Энэ онцлогоороо хөрсний физик өгөршүүлэл ихтэй, тариалан эрхлэхэд тохиромжгүй байдаг ч нар салхины эрчим хүчний их нөөцтэй нутаг юм.


Монгол оронд агаарын жилийн дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн хуваарилалт нутаг дэвсгэрийн янз бүрийн хэсэгт харилцан адилгүй. Зураг 10-д Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан Монгол орны жилийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны нормын (1991-2020 оны) тархалтын мэдээллийг Өмнөговь аймгийн хэмжээнд таслан үзүүлэв.




*Зураг 10. Агаарын жилийн дундаж температур, жилийн нийлбэр хур тунадас (Эх сурвалж: www.irimhe.namem.gov.mn/)*

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олон жилийн дундаж агаарын температур нутгийн хойд хэсгээр +4...+6°C, төвийн уулархаг хэсгээр +2...+4°C мөн нутгийн өмнө хэсгээр +6°C-ээс дээш температуртай байна. Харин жилийн нийлбэр хур тунадас нутгийн ихэнх талбайд 50...150 мм орчим байх бөгөөд говь гурван сайхан орчим 150...200 мм унадаг байна.

Өмнөговь аймгийн уур амьсгалын ерөнхий хандлагыг “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-гийн 2005-2021 оны буюу 16 жилийн мэдээг ашиглан боловсруулав.




*Зураг 11. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн хандлага*

2005-2021 оны олон жилийн явцаас харахад агаарын дундаж температур ойролцоогоор 0.5°С-аар дулаарсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор сүүлийн жилүүдийн (2012 оноос) ерөнхий хандлага нэмэгдсэн нь Зураг 11-т харагдаж байна. Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 2009 онд +4.5°С, хамгийн дулаан жил 2018 онд +6.7°С хүрч байжээ. Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтөөс үзвэл өссөн хандлагатай бөгөөд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 50...242 мм-ийн хооронд хэлбэлзсэн байна.

***Цогтцэций сумын уур амьсгалын горим:*** Цогтцэций сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлтийг Монгол улсын “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн” Дэлхийн цаг уурын байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу Цогтцэцийн цаг уурын станцын (ДТД-1109 м) 1991-2020 оны агаарын температур, хур тунадасны стандарт нормыг цаг хугацааны сарын алхамтай тооцоолсон мэдээг ашиглав.

*Хүснэгт 4. Цогтцэций сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт*

| Үзүүлэлт | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | Жил |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сарын дундаж агаарын температурын үзүүлэлтүүд | | | | | | | | | | | | | |
| Дундаж | -14.7 | -10.5 | -2.6 | 6.6 | 13.9 | 20.2 | 22.7 | 23.2 | 19.7 | 13 | 4.2 | -5.3 | -12.5 |
| Үнэмлэх их температур | 7.2 | 14.4 | 22.7 | 30.2 | 33.2 | 37.4 | 38.3 | 36.5 | 31.6 | 29 | 17.5 | 9.8 | 38.3 |
| Үнэмлэх бага температур | -32.3 | -31.1 | -38 | -16.8 | -12.8 | 1.2 | 3.6 | 0 | -5.9 | -17.6 | -27.3 | -34.2 | -38 |
| Сарын нийлбэр хур тунадасны үзүүлэлтүүд | | | | | | | | | | | | | |
| Нийлбэр | 1.1 | 2.2 | 2 | 1.9 | 9.3 | 17.6 | 30.9 | 25.2 | 10.7 | 3.4 | 1.8 | 1.4 | 107.6 |
| Хамгийн их | 2.2 | 7.3 | 7.2 | 4.4 | 22.5 | 19.9 | 41.1 | 38.2 | 16.0 | 8.4 | 3.7 | 3.1 | 41.1 |

Энэхүү мэдээлэл нь цаг уурын байгууллагаас гарч байгаа мэдээ мэдээллийн ерөнхий суурь нөхцөл болохоос гадна газар тариалан, харилцаа холбоо, барилга байгууламж, авто зам, ачаа тээвэр, эрчим хүч, хот төлөвлөлт зэрэг олон салбаруудын техникийн баримт бичгийн стандарт норм, дүрэм болж ашиглагдах зориулалттай.

Цогтцэций сумын уур амьсгалыг тодорхойлохдоо “Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, ус цаг уурын мэдээллийн төв архив”-аас Цогтцэций станцын сүүлийн 10 жилийн (2012-2021 он) агаарын температур, хур тунадас болон салхины мэдээ, материалыг ашиглав.

**Ус зүй:** Төслийн талбай нь Ус зүйн сүлжээний хувьд Төв азийн гадагш урсгалгүй ай сав, Галба-Өөш-Долоодын говийн сав газарт оршино.

Нийт нутгийн 64.0 хувь буюу 465.6 мян.га нь газрын доорх усны нөөц бага ангилалд ордог. Сумын хэмжээнд 105 худаг, өрөмдмөл 26, богино яндант 8, энгийн уурхайн худаг 196, инженерийн хийцтэй худаг 1438, гар худаг 35, рашаан булаг 15 байна. Эдгээр худаг нь нийт нутгийн 48.0 хувь буюу 350 мян.га бэлчээрийг усаар хангаж байна. Бусад бэлчээр нь зөвхөн өвлийн улиралд цастай үед ашиглах боломжтой байна.

Цогтцэций сумын хойд болон өмнөд талаар орших Гоёот уул, Зогдор уул, Цэций зэрэг уулуудаас орж ирэх түр зуурын урсгал усны голдирлуудаар зун намрын эрчимтэй орсон борооны үед гадаргын урсац орж ирж жижиг тойрмуудыг үүсгэдэг.

Гучингийн сайр, Сайрын хоолой, Өнчингийн тал, Хужитийн тал, Цүнхийн тал, Хэсэг хавиргийн тал, Төхөмийн тал, Шар Төвгийн хоолой, Оорцогийн хоолой зэрэг томоохон хөндийгөөр хур борооны дараа түр зуурын урсац үүсэж, зарим үед гол хэлбэртэй тодорхой хугацаанд урсдаг.

**Хөрсөн бүрхэвч:** Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд бүхэлдээ говийн бор хөрс тархсан байна.

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, шингээгдэх сууриудын нийлбэр хэмжээ дунд, хөдөлгөөнт фосфорын агууламж их, хөдөлгөөнт калийн хангамж дунд зэрэг байна.

**Ургамлын нөмрөг:** Төслийн талбайн район нь Монгол орны байгалийн мужлалаар цөлөрхөг хээрийн (жинхэнэ цөлийн) бүсэд багтана. Ургамал газарзүйн мужлалаар Иран тураны муж, Умард говийн цөлөрхөг хээрийн провинци, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт тус тус багтана. Монгол орны нутгийн 9.35 %-ийг эзэлдэг төдийгүй Монголын цөлөрхөг хээр дэх өвөрмөц газрын нэг бөгөөд говийн бараг бүх элементүүд хуран цугласан.

Төслийн талбайн районд бүхэлдээ таанын-боролз-хялганат бүлгэмдэл тархсан байна. *Stipa gobica, Salsola passerina* зонхилно. Заримдаг сөөгөнцрөөс *Anabasis brevifolia, Artemisia caespitosa, Chenopodium frutescens, Kochia prostrata, Reaumuria soongorica* давамгайлна. Ургамлын дундаж өндөр 4 см, ургамлын тусгаг бүрхэц 20 %, халцгай газрын хэмжээ 80 % байна. 10 $м^2$ талбайд зүйлийн бүрэлдэхүүний тоо 1-3 ш. Ургамлын ургац 0.1 ц/га байна.

**Ан амьтан:** Төслийн талбайн Цогтцэций орчим нь амьтны газарзүйн мужлалаар уулархаг азийн дэд их муж, Монгол Төвөдийн муж, говийн дэд мужийн хойд говийн тойрогт хамаардаг. Энэ нутагт 11 баг, 21 овог, 48 төрөлд хамрагдах 66 зүйл шувуу тэмдэглэгдсэн байна.

Тус суманд гадаргын ус байхгүй, нутгийн ихэнх хэсэг хуурайсаг, харин бороо хур элбэгтэй жилүүдэд Улаан нуур мэтийн шал хоолой дагаж задгайран ус тогтдог нь намар ба зундаа дайрч өнгөрөх, ус хайн орж ирэх хэвлээр явагч, хөхтөн болон шувуудын зүйлүүдэд нэн таатай нөхцөл бүрдүүлдэг.

Хөхтөн, шувуу, мөлхөгчдийн гэх 3 ангид хамаарах 42 зүйлийн сээртэн амьтад байна. Үүнээс 4 баг, 6 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйлийн хөхтөн 16 зүйл шувуу, 8 зүйл мөлхөгчид тархсан болно.

**Хүн ам, эдийн засаг, зам харилцаа:** Өмнөговь аймгийн Цогтцэций сум нь 1924 онд Шанхай уулын хошууны Сэвхүүл хэмээх газар үндэс сууриа тавьж, 1928 оноос одоогийн

байрлаж байгаа Баруун суу хэмээх газар шинээр төвлөрч Цэций нэртэйгээр байгуулагджээ. 1934 оноос одоогийн нэрээр буюу Цогтцэций хэмээн нэрлэх болсон байна. 1927 онд Дэлгэрхангай уулын хошуу тасарч тэмээн хөсгөөр гэр орон, эд хогшил ачиж авчирч хошуу тамгын газар байгуулагдан сургууль, хоршоо, хүний бага эмчийн салбар, гар үйлдвэрийн артель бий болсон нь энэ сумын түүхэн онцлогтой.

*Голлох онцлог:* Сумын хэмжээнд 2813 өрхтэй, 8874 хүн амтай. Энэ онд 12.5 га талбайд ногоо тарьснаас 156.7 тн ургац хурааж авсан байна. Сумын хэмжээнд 288 аж ахуй нэгж, жижиг бизнес эрхлэгч 1290 иргэн үйл ажиллагаагаа явуулж байна. Худалдаа үйлчилгээний газрууд жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Тухайлбал: Эмийн сан-5, Хүнсний үйлдвэрлэлийн тоо-10, Зочид буудал-29, Хүнсний дэлгүүр-36, Супермаркет-10, Хүнсний бөөний төв-5, Нийтийн хоолны газар-37 болж нэмэгдсэн байна.

*Хүн ам:* Цогтцэций сум нь аймгийн төв Даланзадгадаас 100 км-т, Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Дундговь аймгийн Өлзийт сумдтай хил залгаа оршдог. Нийт 72,4 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй.

Сумын хэмжээнд 2021 оны байдлаар 8512 хүн, 2022 оны байдлаар 8874 хүн амьдарч байна. Өмнөх оныхтой харьцуулахад 6.3 %-иар өссөн үзүүлэлттэй байна. Сумын хэмжээнд 2022 оны байдлаар 2813 өрх амьдарч байна.

Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал (ҮСХ-ны даргын 2013 оны 12 сарын 25-ны өдрийн 01/149 тоот тушаал)-ын дагуу тооцсон.

Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээгдэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ.

# БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## *3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт*

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 5. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл*

| Байгаль орчны үзүүлэлт | Шууд | Шууд бус | Өөрөөр зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Бүцаж нөлөөлөх | Бүцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд эрэг | Бага зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт* | | | | | | | | | | |
| Газрын доорх урсцын өөрчлөлт | | | х | | | | | | | |
| Гадаргын урсцын өөрчлөлт | | | х | | | | | | | |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт | х | | | | х | | | | | х |
| Хөрсний элэгдэл, эвдрэл | х | | | | х | | | | | х |
| Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт | | | х | | | | | | | |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт | | | х | | | | | | | |
| *2. Байгалийн нөөц ашиглалт* | | | | | | | | | | |
| Газрын гадаргын нөөц баялаг | | | х | | | | | | | |
| Бэлчээрийн байдал | | | х | | | | | | | |
| Эрдэс түүхий эдийн нөөц | | | х | | | | | | | |
| Эрчим хүчний нөөц | | | х | | | | | | | |
| *3. Байгаль, орчны өөрчлөлт* | | | | | | | | | | |
| Газрын доорх усны чанар, хэмжээ | | | х | | | | | | | |
| Гадаргын усны чанар хэмжээ | | | х | | | | | | | |
| Агаарын бохирдол | | | х | | | | | | | |
| Хөрсний бохирдол | | | х | | | | | | | |
| Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх | | | х | | | | | | | |
| Дуу чимээ, шуугианы нөлөө | | | х | | | | | | | |
| *4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор* | | | | | | | | | | |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх | | | х | | | | | | | |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх | | | х | | | | | | | |
| Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх | | | х | | | | | | | |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх | | | х | | | | | | | |
| Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх | | | х | | | | | | | |
| *5. Нийгэмд үзүүлэх нөлөө* | | | | | | | | | | |
| Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх | | х | | | х | | | | + | |
| Үйлчилгээний салбарын үүа-нд нөлөөлөх | | х | | | х | | | | | + |

| Байгаль орчны үзүүлэлт | Шууд | Шууд бус | Өөрөөр зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Бүцаж нөлөөлөх | Бүцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд эрэг | Бага зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх | | x | | | x | | | | + | |
| Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх | | | x | | | | | | | |
| *6. Эдийн засагт үзүүлэх нөлөө* | | | | | | | | | | |
| Татварын орлого өөрчлөгдөх | x | | | | x | | x | | | + |
| Орон нутгийн орлого нэмэгдэх | x | | | | x | | x | | | + |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох | x | | | | x | | x | | | + |
| Ажлын байр нэмэгдэх | x | | | | x | | x | | | + |
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх | x | | | | x | | x | | | + |
| *7. Бусад нөлөөлөл* | | | | | | | | | | |
| Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах | | | x | | | | | | | |
| Дүн | 7 | 3 | 21 | 0 | 10 | 0 | 5 | 0 | 2 | 8 |
| Дүн | 7 | 3 | 21 | 0 | 10 | 0 | 5 | 0 | 2 | 8 |

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

*Шууд нөлөөлөл:*

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө.

*Шууд бус нөлөөлөл:*

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө.

*Хүчтэй нөлөөлөл:*

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

## БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах “Өгөөмөр мандал хайрхан” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр”-ийн төслийн БОМТ-г БОУАӨЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 1-р хавсралтыг баримтлан боловсруулсан болно.

***Зорилго:*** Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

***Гол зорилтуд:***

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх.

*Хүснэгт 6. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэгтгэл 5 жилээр*

| Арга хэмжээ | 2024 он | 2025 он | **2026 он** | 2027 он | 2028 он | Нийт зардал мян.төг |
|---|---|---|---|---|---|---|
| Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | 2,610.0 | 10,970.0 | **2,110.0** | 2,110.0 | 2,110.0 | 19,910.0 |
| Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 2,752.0 | 2,752.0 | **2,752.0** | 2,752.0 | 2,752.0 | 13,760.0 |
| Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | УАЗ | УАЗ | **УАЗ** | УАЗ | УАЗ | УАЗ |
| Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2,800.0 | 2,300.0 | **2,300.0** | 2,300.0 | 2,300.0 | 12,000.0 |
| Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | 2,200.0 | 5,200.0 | **200.0** | 200.0 | 200.0 | 8,000.0 |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 6,000.0 | 6,000.0 | **6,000.0** | УАЗ | УАЗ | 18,000.0 |
| Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 400.0 | 400.0 | **400.0** | 400.0 | 400.0 | 2,000.0 |
| Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь | - | - | **-** | - | - | - |
| **Нийт** | **16,762.0** | **27,622.0** | **13,762.0** | **7,762.0** | **7,762.0** | **73,670.0** |

*Хүснэгт 7. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал*

| № | Ажлын нэр | Зардал, мян.төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 2,110.0 |
| 2 | Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 2,752.0 |
| 3 | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |

| № | Ажлын нэр | Зардал, мян.төг |
|---|---|---|
| 4 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | 200.0 |
| 5 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2,300.0 |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 400.0 |
| 7 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 6,000.0 |
| 8 | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | 400.0 |
| **Нийт дүн** | | **13,762.0** |

## БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ ХАМГААЛАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 8. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ*


| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (Төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | | | | | |
| 1 | Авто тээврийн хэрэгслээс хорт хий ялгарах, дуу чимээ тархах | Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж буй машин техникийг үзлэг, оношилгоонд тогтмол оруулж, засвар үйлчилгээг шаардлагын дагуу хийж гүйцэтгэж байх | Үйлдвэрийн машин | Жилд 1 удаа | - | - | 1,000.0 | 2026 он | Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2025 |
| **Дүн** | | | | | | | **1,000.0** | | |
| Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | | | | | |
| 2 | Усны чанар | Ус ашиглагч нь цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ. | Бохир ус зайлуулах цооног, түүнээс үүсэх бохирдлыг хязгаарлах | Удаа | 150.0 | Улиралд 1 | 1,110.0 | 2026 он | БОУАӨЯ-ын сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам |
| **Дүн** | | | | | | | **1,110.0** | | |
| Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | | | | | |
| 3 | Хөрсний бохирдол | Төслийн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах | Төслийн талбайд | Тогтмол | Үйл ажиллагааны зардал | | | 2026 он | MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, бохирдлыг үнэлэх” |
| 4 | | Авто машины зогсоол дээр асгарсан тос, тосолгооны материалыг тухай бүрд нь цэвэрлэж авах | Төслийн талбайд | удаа | Үйл ажиллагааны зардал | | | 2026 он | |
| **Дүн** | | | | | | | - | | |
| Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | | | | | |
| 60 | Ургамал | Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих | Төслийн талбай | 50ш | Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан | | | 2026 он | Нөхөн сэргээлтийн аргачлал Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай |
| **Дүн** | | | | | | | - | | |
| **Нийт дүн** | | | | | | | **2,110.0** | | |

## БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна.

*Хүснэгт 9. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө*

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ногоон байгууламж бий болгох | Бүйлс, сухай | Төслийн талбайд мод бут тариална., шар хуасан хашаанд | $м^2$ | 50 | 250.0 | 2026 он | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль<br><br>Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011 |
| | | Харгана | | $м^2$ | 50 | 400.0 | 2026 он | |
| | | Зүлэгжүүлэх | | кг | 100 | 200.0 | 2026 он | |
| 2 | Хар шороо | Хар шороо, элс, бордоо зэргийг бэлтгэх | Ногоон байгууламжийн арчилгаа | Машин | 2 | 272.0 | 2026 он | |
| 3 | Элс | | | Шуудай /40кг/ | 0.5 | 50.0 | 2026 он | |
| 4 | Гумины бордоо | | | Уут | 4 | 30.0 | 2026 он | |
| 5 | Цалин | 2 хүн ажиллах жилд 2 удаа, 2 өдрөөр | | Өдөр | 2 | 1,550.0 | 2026 он | |
| **Нийт дүн** | | | | | | **2,752.0** | | |




*Зураг 12. Төслийн талбайн ногоон байгууламжийн төлөвлөлтийн зураг*

## БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;
- Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-ын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээн ажиллана.

*Хүснэгт 10. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Археологийн дурсгал | Хэрэв үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой. | Төслийн талбай | - | Зардал тооцох боломжгүй | Зардал тооцох боломжгүй | 2026 он | Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/ , Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд |
| 2 | Палеонтологийн дурсгал | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | - | | |

## БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Эзэмшил газрын ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж цэвэрлэж байх | Үйлдвэрийн ойр орчмын 100 м-т | Тогтмол | Үйл ажиллагааны зардал | | | 2026 он | БОУАӨЯ-ны сайдын А/433 тогтоол Хог хаягдлын тухай хууль |
| 3 | Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах | Төслийн талбайд | Иж бүрэн | Үйл ажиллагааны зардал | | | 2026 он | |
| 4 | Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх | Дахин ашиглагдах хог хаягдал | Тогтмол | Үйл ажиллагааны зардал | | | 2026 он | |
| 5 | Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх | Хог хаягдлын цэгт | Тогтмол | Үйл ажиллагааны зардал | | | 2026 он | |
| 6 | Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх | Үйлдвэрийн ажилчдад | Удаа | Үйл ажиллагааны зардал | | | 2026 он | Засгийн газрын 116 тогтоол |
| 7 | Бетоны чанар сайжруулахад ашигласан нэмэлтийн сав, үлдэгдэл болон бусад аюултай хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй саванд цуглуулж, эрх бүхий байгууллагаар дамжуулан тээвэрлүүлж, хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах. | Үйлдвэр | Тогтмол | Гэрээний үнийн дүнгээр | | | 2026 он | Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам |
| **Нийт дүн** | | | | | | **200.0** | | |

## БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*


| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох | Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах | Нийт ажилчид | Жилд 1 удаа | 19 хүн | 1,000.0 | | 2026 он | Гамшгаас хамгаалах тухай хууль |
| 2 | Олон нийт, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл | Ажиллагсдыг ХАБЭА -н хувцас хэрэгсэл буюу бээлий, малгай, хормогч, маск, хошуувч, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх; | Төслийн бүх ажилчид | Иж бүрэн | Жил бүр | Үйл ажиллагааны хүрээнд | | 2026 он | Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль |
| 3 | | Төслийн бүх ажилчдад өдөр бүр ажил эхлэхээс өмнө ХАБЭА -н зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХАБЭА -н зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох | | - | Өдөр бүр | 1,300.0 | | 2026 он | MNS 5002:2000, “ХАБЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” |
| 4 | | Төслийн хүрээнд ашиглагдах техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих | Иж бүрэн | Иж бүрэн | Өдөр бүр | Үйл ажиллагааны хүрээнд | | 2026 он | MNS ISO 13688:2000, “ХАБЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” |
| 5 | | Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх. Анхан шатны тусламжийн эм, тариа, багажийг хяналтын өрөө эсвэл ажлын байруудын аль тохиромжтой газар байрлуулах. | Төслийн бүх ажилчдад | Удаа | Тухай бүр | Гэрээний үнийн дүнгээр | | 2026 он | MNS 5390:2004, “ХАБЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” |
| **Нийт дүн** | | | | | | **2,300.0** | | | |

## БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан мониторингийн цэгээс хөрс, ус, агаарын дээжийг тогтмол хугацаанд авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж. Байгаль орчны хяналт шинжилгээний тайлангийн үр дүнг жил бүрийн БОМТ-ний биелэлтийн тайланд тусгаж төсөл хэрэгжих сумдын багийн удирдлага болон нөлөөллийн бүсийн иргэдэд нээлттэй мэдээлж байх шаардлагатай.

*Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Хяналтын цэгийн байршил | Хугацаа давтамж | Давтамж ийн тоо | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хууль, бодлого, стандарт |
|---|---|---|---|---|---|---|
| Агаарын чанар | | | | | | |
| $CO_2$, $NO_2$, $SO_2$<br>Тоос нийт (PM10, PM2.5)<br>Дуу шуугиан хэмжээ | - Үйлдвэрийн байр дотор -1 цэг<br>- Төслийн талбайн хашаан дотор-3 цэг | Жилд 1 удаа | 4 цэгт | 50,000 | 100,000 | MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн шаардлага |
| Хөрс | | | | | | |
| Нянгийн шинжилгээ/<br>Нянгийн ерөнхий тоо, гэдэсний бүлгийн нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, E.Coli халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо/ | - Ариун цэврийн байгууламж-1 цэг<br>- Хогийн цэг – 1 цэг | Жилд 1 удаа | 2 цэгт | 50,000 | 100,000 | - MNS 3297:2019, "Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх"<br>- MNS 5850:2019, "Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ" |
| Хөрсний хүнд металлууд<br>Нийт 21 элементээр шинжилгээ хийлгэх | - Төслийн талбайн ил гарсан хөрснөөс-1 цэг | Жилд 1 удаа | 1 цэгт | 100,000 | 100,000 | |
| Усны чанар | | | | | | |
| Усны ерөнхий хими, Бактериологи | - Унд, ахуйн ус | Жилд 1 удаа | 1 цэгт | 100,000 | 100,000 | - MNS 0900:2018 "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" |
| **1 жилийн ОХШХ-ийн зардал** | | | | | **400,000** | |




*Зураг 13. ОХШХ-ийн зураг*

## БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа хуваарь | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2026 он | | | | |
| | | | сар | сар | сар | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах. | 3,000.0 | 6-р сар | | | “Өгөөмөр мандал хайрхан” ХХК | Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3 |
| 2 | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх | 3,000.0 | | 10-р сар | | “Өгөөмөр мандал хайрхан” ХХК | Газрын тухай хуулийн 58.5 |
| **Нийт зардал** | | **6,000.0** | | | | | |

## БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ.

*Хүснэгт 15. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө*

| БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд | Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр | Мэдээний агуулга | Хугацааны тов | Хэлэлцүүлгээр санал авах чиглэл | Нийт төсөв мян.төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан |
|---|---|---|---|---|---|---|
| Төрийн захиргааны төв байгууллагад | БОМТ-н жилийн төлөвлөгөө | БОННҮ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах | Жил бүрийн 12-р сард | Төлөвлөгөө батлуулах | 150.0 | “Өгөөмөр мандал хайрхан” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн |
| Аймгийн БОГ | БОМТ-н жилийн тайлан | Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт | Жил бүр 11-р сарын 1-ний дотор | Тайлан хянуулах | 150.0 | “Өгөөмөр мандал хайрхан” ХХК -ийн байгаль орчны мэргэжилтэн |
| **Нийт дүн** | | | **-** | | **300.0** | |